



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ХЭРЛЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 22 өдөр

Дугаар А/109

Чингис хот

┌ Хязгаарлалтын дэглэм тогтоох тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 16.1.2, 17 дугаар зүйлийн 17.2, 17.2.1, 18 дугаар зүйлийн 18.3, 18.4, 18.5 Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын Булаг багт Улсын Мал Эмнэлэг Ариун Цэврийн Төв Лабораторийн 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 25-2026 тоот шинжилгээний дүнгээр адууны ям өвчин оношлогдсон тул хязгаарлалтын дэглэмийг тогтоосугай.

2.Голомтын бүсийн мал, амьтанд үзлэг тандалт, халдваргүйтгэл хийж ажиллахыг Өндөрбилгэх мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч (Т.Сансарбаатар)-д даалгасугай.

3.Голомтын бүсийн мал амьтны шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн улсын байцаагч (Д.Сандагдорж)-д үүрэг болгосугай.

4.Голомтын хашаа хороог халдваргүйжүүлэх, адууны ям өвчнөөр өвчилсөн адууг устгахад шаардагдах зардал 487500 (дөрвөн зуун наян долоон мянга таван зуу) төгрөгийг гамшгийн эрсдэлийн сангаас гаргахыг нягтлан бодогч (Д.Баярцэцэг)-д зөвшөөрсүгэй.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Лхагвабаатар)-д даалгасугай.

ДАРГА



Д.ЭРДЭНЭБААТАР

Хэрлэн сумын Засаг даргын 2025 оны
04 дугаар сарын 22-ны өдрийн 17/209
дугаар захирамжийн хавсралт

Голомтын хашаа хороог халдваргүйжүүлэх,
адууны ям өвчнөөр өвчилсөн адууг устгахад шаардагдах зардал

Д/Д	Шаардагдах материал	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Олгох хэмжээ	Нийт
1	Дизель түлш	Л	3250	150	487500